

ЭРХ ЗҮЙН ОНОЛ

1. Эрх зүй нь позитив онолын хувьд

- a. эрх зүйн хэм хэмжээтэй давхцсан ойлголт
- b. эрх зүйн хэм хэмжээнээс өргөн ойлголт
- c. эрх зүйн хэм хэмжээнээс явцуу ойлголт

2. Эрх зүй нь жам ёсны эрхийн онолын хувьд

- a. эрх зүйн хэм хэмжээнд үндэслэсэн ойлголт
- b. эрх зүйн хэм хэмжээг үндэслэх ойлголт
- c. эдгээрийн аль нь ч биш

3. Субъектив эрх

- a. эрх зүйн хэм хэмжээнд
- b. эрх зүйн үзэл баримтлалд
- c. эрх зүйн мөн чанарт
- d. эрх зүйн хэрэгжилтэд илүү хамаатай ойлголт

4. Объектив эрх

- a. эрх зүйн хэм хэмжээнд
- b. эрх зүйн үзэл баримтлалд
- c. эрх зүйн мөн чанарт
- d. эрх зүйн хэрэгжилтэд илүү хамаатай ойлголт

5. Эрх зүйн мөн чанар эрх зүйт төрийн онол ёсоор

- a. жам ёсны байдал
- b. захиргааны албадлага
- c. төрийн хүлээн зөвшөөрөл
- d. шүүхийн хэрэглээгээр илэрхийлэгдэнэ

6. Эрх зүйн мөн чанар

- a. заавал биелэгдэх шинжээр
- b. эрх зүйт төрийн зарчмуудаар
- c. төрийн хөгжлийн түвшингээр
- d. эрх зүйн уламжлалт байдлаар гол нь тодорхойлогдоно

7. Эрх зүйн мөн чанар төрийн хүсэл зоригоор тодорхойлогдоно гэж үздэг онол

- a. материалист онол
- b. нормативист онол
- c. зүй ёсны процедурын онол
- d. хууль тогтоох онол

8. Үүсмэл эрх зүйн хэлбэршлийг бий болгох арга зам (Монголын хувьд)

- a. заншлын эрх зүй
- b. хууль тогтоогчийн эрх зүй
- c. шүүхийн эрх зүй

9. Социалист эрх зүйн мөн чанарыг "бутагч охин" гэж тодорхойлдог онол

- a. Америкийн онол
- b. Францын онол
- c. Германы онол

10. "Хууль тогтоомж" гэсэн ойлголт нь багтаамжаараа

- a. парламентаас баталсан эрх зүйн баримт бичгийн хүрээнд
- b. шүүхэд хэрэглэгддэг эх сурвалжийн хүрээнд
- c. хууль тогтоох болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлээс гаргаж буй бүх

баримт бичгийн хувьд

d. хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн баримт бичгүүдийн хувьд ойлгогдоно

11. Суурь хэм хэмжээ гэдэгт (үл хамаарахыг ол)

a. иргэний үндсэн эрх

b. эрх мэдэл хуваарилах зарчим

c. Үндсэн хуулийн дархлаа, хамгаалал

d. ардчиллын үндсэн хэм хэмжээ

e. эдгээрийн аль нь ч биш

12. Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэх зарчим нь

a. ардчиллын онол

b. нийгмийн гэрээний онол

c. эрх зүйт төрийн онол

d. хууль тогтоох онолд үндэслэгдсэн байдаг

13. Дараахь эрх зүйн салбаруудын алинд нь төсөөтэй хэрэглэх зарчмыг хэрэглэж болох вэ?

a. процессын эрх зүйд

b. материаллаг эрх зүйд

c. нийтийн эрх зүйд

d. хувийн эрх зүйд

14. Хүн бүр эрх зүйн этгээд байна гэх зарчим нь

a. шударга ёсны зарчим

b. тэгш эрхийн зарчим

c. ардчилсан ёсны зарчим

d. хууль дээдлэх зарчим

e. эв нэгдлийг хангах зарчим

15. Эрх зүйт төрийн хэлбэрийн тал (идеал)-д хамаарах зарчим

a. хууль хараат бус, бие даасан шүүхэд хэрэглэгддэг байх

b. хууль эрх мэдлийг хуваарилаж, хязгаарласан байх

c. хууль хүний эрхэд үндэслэгдэж, түүгээр тайлбарлагддаг байх

d. хуулийн тогтолцоонд Үндсэн хууль дээдлэгддэг байх

e. хууль урьдчилан таагдахуйц тогтвортой, тодорхой байх

16. Эрх зүйт төрийн агуулгын (идеал)-д хамаарах зарчим

a. хууль түгээмэл шинжтэй байх

b. хууль тодорхой бичилттэй байх

c. хууль хүний эрхэд үндэслэгдсэн байх

d. хууль нээлттэй, ил байх

e. хууль өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх

17. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэсэн зарчим

a. үйл ажиллагааны зарчим

b. чиг үүргийн зарчим

c. бүтцийн зарчим

18. Шүүн таслах үйл ажиллагааг шүүхээс гадуур явуулахыг хориглоно гэсэн зарчим

a. үйл ажиллагааны зарчим

b. чиг үүргийн зарчим

c. бүтцийн зарчим

19. Шударга шүүх нь

a. хууль ёсны шүүх гэсэн ойлголттой адил

b. хууль ёсны шүүх гэсэн ойлголтоос ялгаатай

с. зөв хариулт алга байна

20. Шударгаар шүүлгэх эрх

a. үйл ажиллагааны агуулгатай

b. бүтцийн агуулгатай

с. чиг үүргийн агуулгатай

21. Шүүхийн сэтгэлгээний тогтолцоо нь индуктив байдаг эрх зүйн тогтолцоо

a. Социалист эрх зүйн бүл

b. Иргэнлэг эрх зүйн бүл

с. Нийтлэг эрх зүйн бүл

22. Шүүгч гагцхүү хуульд захирагдах гэх зарчим

a. шүүхэд хэрэглэх эх сурвалжид хамаатай зарчим

b. шүүн таслах үйл ажиллагаанд хамаатай зарчим

с. эдгээрт хоёланд нь хамаатай зарчим

23. Хууль дээдлэх зарчим

a. иргэнд илүү хамаатай

b. төрд илүү хамаатай

с. эдгээрт адил хамаатай

24. Эрх зүйт төрийн зарчмаар шалгуур хийвэл эрх зүйн тогтолцоог

a. өрнийн ба хуурмаг өрнийн, өрнийн бус

b. нийтлэг, иргэнлэг, социалист

с. шашинт, шашинт бус

d. уламжлалт, улс төржсөн, мэрэгшсэн гэж ангилна

25. Үндсэн хуулийн зарчим бүрэлдэн хөгжихөд нөлөөлсөн онолууд (үл хамаарахыг ол)

a. жам ёсны эрхийн онол

b. иерархи онол

с. эрх мэдэл хуваарилах онол

d. нийгмийн гэрээний онол

e. зөв хариулт алга байна

26. Нийгмийн хамгааллын тогтолцоо нь эрх зүйн аль зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг вэ?

a. шударга ёсны зарчим

b. ардчилсан зарчим

с. тэгш эрхийн зарчим

d. хүмүүнлэг зарчим

27. Олонхоороо шийдвэрлэж, цөөнхийг хамгаалах зарчим нь

a. шударга ёсны зарчим

b. ардчилсан зарчим

с. тэгш эрхийн зарчим

28. Нэгэн удаа Иракийн удирдагч асан Садам Хуссейн “Би Иракт шинэ Үндсэн хууль тогтооно” гэж зарласан гэдэг. Энэ нь эрх зүйг өөрийг нь бүтээж байдаг ямар зарчмыг зөрчсөн бэ?

a. Эрх зүйн эх сурвалжууд нь бие биенээ шатлан захирдаг байх

b. Нийтлэг байх

с. Ухаалаг (рационал) байх

d. Тодорхой байх

29. Монгол Улсын Иргэнд Газар Өмчлүүлэх тухай хуулийн 5.1.4-т “иргэн, түүний гэр бүлийн гишүүн-Монгол Улсын иргэнд дундаа хамтран өмчлөх хэлбэрээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар

газрыг нэг удаа үнэгүй өмчлүүлнэ” гэж заасан. Өөрөөр хэлбэр, гэр бүл болоогүй Монгол улсын иргэн ийм эрх эдлэх боломжгүй гэсэн үг. Энэ нь эрх зүйн ямар зарчмыг зөрчсөн бэ?

- a. Эрх зүйн эх сурвалжууд нь бие биенээ шатлан захирдаг байх
- b. Нийтлэг байх
- c. Ухаалаг (рационал) байх
- d. Тодорхой байх

30. Шүүгч шийдвэрийнхээ үндэслэлийг хангалттай гаргаагүй буюу үндэслэгээ нь тодорхой бус байгаа бол энэ нь эрх зүйн ямар зарчмыг зөрчсөн бэ?

- a. Нийтэд зарлагдсан байх
- b. Нийтлэг байх
- c. Ухаалаг байх
- d. Эрх зүйн эх сурвалжууд нь бие биенээ шатлан захирдаг байх
- e. Тодорхой байх

31. Эрх зүй, төрийн онолыг эрх зүйн сургалтад суурь хичээл байдлаар чухалчилан авч үздэг сургалтын уламжлал аль үндэсний эрх зүйгээс үүсэлтэй вэ?

- a. Германы эрх зүй
- b. Английн эрх зүй
- c. Оросын эрх зүй
- d. Америкийн эрх зүй
- e. Францын эрх зүй

32. Эрх зүйн хэм хэмжээний төрөл (үл хамаарахыг ол)

- a. эрх олгосон хэм хэмжээ
- b. үүрэг болгосон хэм хэмжээ
- c. хууль бус үйлдэл
- d. хориглосон хэм хэмжээ

33. Эрх зүйн хэм хэмжээний үндсэн шинж

- a. Нийтлэг нөхцлөөр илэрнэ
- b. Дахин давтагдах шинжтэй
- c. Зайлшгүй шинжтэй
- d. Дээрхи бүгд зөв

34. Эрх зүйн хэм хэмжээг зохицуулах шинжээр нь

- a. Зохицуулах ба хамгаалах
- b. Хамгаалах ба бэхжүүлэх
- c. Императив ба диспозитив
- d. Ерөнхий ба тусгай

35. Зохицуулах хэм хэмжээ

- a. Төрийн албадлага хэрэглэх нөхцлийг заадаг
- b. Тодорхой төрлийн зан үйлийг хязгаарладаг
- c. Субъектив эрх, хууль зүйн үүрэг үүсэх үндсэн нөхцлийг тусгадаг
- d. Эерэг агуулгатай үйлдэл хийхийг зөвшөөрдөг

36. Иргэд шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нь

- a. Зохицуулах хэм хэмжээ
- b. Хамгаалах хэм хэмжээ
- c. Хориглосон хэм хэмжээ
- d. Эрх олгосон хэм хэмжээ
- e. Үүрэг болгосон хэм хэмжээ

37. Төрийн нууцыг задруулахгүй байх нь

- a. Императив хэм хэмжээ
- b. Диспозитив хэм хэмжээ
- c. Хориглосон хэм хэмжээ
- d. Нөхөн сэргээх хэм хэмжээ

38. Эрх зүйн хэм хэмжээ нь

- a. Тодорхой бус хүрээний этгээдэд үйлчлэх нийтлэг дүрэм журам
- b. Эрх зүйн эх сурвалжид илэрхийлэгдсэн зан үйлийн журам
- c. Нийтээр заавал дагаж мөрдөх зан үйлийн журам
- d. Эрх зүйн номлол
- e. Шүүхийн шийдвэр

39. Императив хэм хэмжээ нь (үл хамаарахыг ол)

- a. Ямар нэг сонголгүйгээр томъёологдсон
- b. Субъектийн санаа зоригоос үл хамааралтай
- c. Субъектийн чөлөөт хүсэл зоригт тулгуурладаг
- d. Гэрээний эрх зүйд хамаарна

40. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял оногдуулах нь

- a. Дефинитив хэм хэмжээ
- b. Нөхөн сэргээх хэм хэмжээ
- c. Хамгаалах хэм хэмжээ
- d. Зохицуулах хэм хэмжээ
- e. Декларатив хэм хэмжээ

41. Орон сууцны хөлс төлөх нь

- a. Декларатив хэм хэмжээ
- b. Оператив хэм хэмжээ
- c. Зөвшөөрсөн хэм хэмжээ
- d. Үүрэг болгосон хэм хэмжээ
- e. Хамгаалах хэм хэмжээ

42. Эрх зүйн актын үйлчлэлийн эхлэл, төгсгөлийг зааж өгсөн нь

- a. Дефинитив хэм хэмжээ
- b. Оператив хэм хэмжээ
- c. Императив хэм хэмжээ
- d. Диспозитив хэм хэмжээ
- e. Нөхөн сэргээх хэм хэмжээ

43. Эрх, үүрэг үүсэх нөхцөл заасан хэсэг

- a. Сонгох диспозиц
- b. Харьцангуй тодорхой санкци
- c. Гипотез
- d. Диспозиц
- e. Санкци

44. Эрх, үүргийг заасан хэсэг

- a. Нийлмэл гипотез
- b. Сонгох санкци
- c. Диспозиц
- d. Санкци
- e. Гипотез

45. Шийтгэл, хариуцлага заасан хэсэг

- a. Санкци
- b. Диспозиц
- c. Гипотез
- d. Иш татсан диспозиц

46. Зохицуулах хэм хэмжээнд гол төлөв

- a. Гипотез болон санкци хамаарна
- b. Диспозиц болон санкци байна
- c. Гипотез болон диспозиц агуулагдана
- d. Дээрхи бүгд зөв
- e. Зөв хариулт алга байна

47. Хамгаалах хэм хэмжээ нь гол төлөв

- a. Гипотез болон санкцаас бүтдэг
- b. Диспозиц болон санкцийг агуулдаг
- c. Гипотез болон диспозиц байдаг
- d. Зөвхөн санкцаас хамаарна

48. Дадал зуршил ба хэм хэмжээний гол ялгаа (үл хамаарахыг ол)

- a. Дахин давтагдах шинжтэй
- b. Хүмүүсийн зан үйлийг журамладаг
- c. Үүрэгжсэн байдлыг шаарддаг
- d. Зайлшгүй шинжтэй

49. “Ёс суртахууны хэм хэмжээ”, “Эрх зүйн хэм хэмжээ” гэсэн ойлголт

- a. Агуулга, багтаамжийн хувьд адил
- b. Ёс суртахууны хэм хэмжээ нь өргөн хүрээтэй
- c. Эрх зүйн хэм хэмжээ нь өргөн хүрээтэй
- d. Үнэлэмжээс хамаарна

50. Эрх зүйн хэм хэмжээний гадаад хэлбэр нь (үл хамаарахыг ол)

- a. Үндсэн хууль
- b. Олон улсын гэрээ
- c. Хэм хэмжээ тогтоосон акт
- d. Эрх зүйн номлол
- e. Библи

51. Диспозицийг зан үйлийг илэрхийлсэн байдлаар нь (үл хамаарахыг ол)

- a. Шууд, иш татсан, бланкет
- b. Эрх олгосон, үүрэг хүлээлгэсэн, хориглосон
- c. Сонгох, иш татсан, бланкет
- d. Туйлын, харьцангуй, тусгай

52. Үндсэн хууль нь

- a. юунд ч үл хязгаарлагдана.
- b. хууль тогтоомжийг хязгаарладаг.
- c. өөрийгөө хязгаарладаг.
- d. удирдагчийн хүсэл зоригоос хамааралтай.

53. Ухаалаг (рационал) биш хууль байж болох уу?

- a. Болно
- b. Болохгүй
- c. Ямар ч байж болно

54. Эрх зүйн агуулгын эх сурвалж (үл хамаарахыг ол)

- a. Нийгмийн харилцааг зохицуулах болсон улс төр, эдийн засаг, техник технологийн дэвшил зэрэг бусад хүчин зүйлс
- b. Эрх зүйн үзэл номлол, сургаал
- c. Эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох албан ёсны хэлбэр
- d. Эрх зүйн хэмжээний илрэх гадаад хэлбэр

e. Эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд хэрэглэж буй зарчмууд
f. Хууль цаазын түүхэн эх сурвалжууд (Их засаг, Хутагтай сэцэн хунтайжийн шашны цааз, Монгол-Ойрдын их цааз, Халх журам)
55. Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн агуулгын эх сурвалжийг ол.

- a. Үндсэн хууль
- b. Эрүүгийн хууль
- c. Мэдээлэл технологийн дэвшил
- d. Гэм буруугийн объектив тал
- e. Гэм буруугийн субъектив тал

56. Эрх зүйн хэлбэрийн эх сурвалж

- a. Эрх зүйн эх сурвалжийн илрэх гадаад хэлбэр
- b. Эрх зүйн эх сурвалжийг илэрхийлэх буюу бэхжүүлэх албан ёсны хэлбэр
- c. Эрх зүйн маргааныг шийдвэрлэхэд хэрэглэж буй хэм хэмжээний зарчмууд
- d. Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт
- e. Шүүхийн хэвшүүлэн тогтоох хэм хэмжээ

57. Хууль тогтоох үйл ажиллагааны үр дүнд

- a. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт
- b. Эрх зүйн номлол
- c. Эрх зүйн заншил
- d. Шүүхийн хэвшүүлэлт
- e. Эрх зүй

58. Хууль (lex)

- a. Шударга ёсны хэмжүүр
- b. Нийгмийн харилцааг хамгаалах хэрэгсэл
- c. Ард түмний хүсэл зориг
- d. Жам ёсны тусгал
- e. Хүний эрх, эрх чөлөөний баталгаа
- f. Зан үйлийн боломж

59. Хууль зүйн хүчин чадлаар нь

- a. Органик хууль
- b. Үндсэн хууль
- c. Төрөлжсөн хууль
- d. Хууль цааз
- e. Бусад хууль

60. Хуульд тавих үндсэн шаардлага

- a. Агуулга, хэлбэрийн хувьд боловсронгуй байх
- b. Шударга ёсны хэмжүүр байх
- c. Нийгмийн харилцааг төрөлжүүлэн зохицуулах
- d. Нийгмийн үндсэн асуудлыг зохицуулах
- e. Хариуцлага тодорхой байх

61. Кодекс

- a. Төрлийн буюу ойролцоо шинжтэй нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээнүүдийг нэгтгэн системчилсэн хуульчилсан акт
- b. Нийгмийн харилцааг зохицуулах үндсэн шинжтэй бүлэг хэм хэмжээнүүдийг нэгтгэн системчилсэн акт
- c. Эрх зүйн хэм хэмжээнүүдийг нэгтгэн системчилсэн хуульчилсан акт

62. Кодексын шинж (үл хамаарахыг ол)

- a. Кодексоор зохицуулагдаж байгаа зүйлүүд нь бусад хуулиудтай адил тэгш байна. (иргэний хууль нь бусад иргэний хууль тогтоомжтой адил тэгш байна)
- b. Бүлэг бүрийн логик уялдаа, харилцан хамаарал
- c. Кодексоор зохицуулах зүйлийн нэг бүрчилсэн шинж
- d. Хэрэглэх, хэрэгжүүлэхэд ойлгомжтой байх
- e. Албан ёсны шинж (Албан ёсны дагуу явагдсан хууль тогтоох процесс)

63. Төрийн эрх зүйн заавал биелэгдэх эх сурвалж (Ром-Германы эрх зүйн бүлд)

- a. Үндсэн хууль
- b. Зан заншлын хэм хэмжээ
- c. Хууль, хуульчилсан акт
- d. Олон улсын гэрээ
- e. Эртний номлол

64. Захиргааны эрх зүйн эх сурвалж

- a. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр
- b. Засаг даргын удирдлага зохион байгуулалтын шинж бүхий захирамж
- c. Аж ахуйн нэгж байгууллагын захирлын тушаал
- d. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- e. Гадаад улсын захиргааны шүүхийн шийдвэр

65. Эрүүгийн эрх зүйн эх сурвалж (үл хамаарахыг ол)

- a. Үндсэн хууль
- b. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээ
- c. Хүний эрхийн олон улсын конвенц
- d. Эрүүгийн хууль
- e. Гадаад улсын эрүүгийн хууль

66. Эрх зүйн эх сурвалжийн бүл

- a. Англи-Америкийн эрх зүй
- b. Пост-Социалист улс орнуудын эрх зүй
- c. Ази дорно дахины эрх зүй
- d. Америк эрх зүй
- e. Дундад азийн эрх зүй

67. Английн эрх зүйд заавал биелэгдэх эрх зүйн эх сурвалж

- a. Гадаад орнуудын хууль
- b. Оюун ухаан (reason, natural law)
- c. Номлол
- d. Вангийн дархан эрх ямба
- e. Хуульчилсан актууд

68. Аливаа эрх зүйн бүлд эх сурвалжийг (үл хамаарахыг ол)

- a. Ёсчлон биелүүлэх эх сурвалж
- b. Нийтээр дагаж мөрдөх эх сурвалж
- c. Заавал биелэгдэх шинжгүй эх сурвалж
- d. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээ буюу эх сурвалж
- e. Цөөнхөд хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалж

69. Ром Германы эрх зүйн бүлд заавал биелэгдэх эх сурвалж

- a. Каноны эрх зүй
- b. Гадаад орны хууль
- c. Хуульчилсан актууд

- d. Эртний зан заншил
- e. Номлол

70. Эрх зүйн акт (үл хамаарахыг ол)

- a. Үндсэн хууль
- b. Ерөнхийлөгчийн зарлиг
- c. Засгийн газрын тогтоол
- d. Засаг даргын захирамж
- e. Төрөлжсөн хуулиуд

71. Англи-Америкийн эрх зүйд заавал биелэгдэх эх сурвалж

- a. Эрний номлолууд
- b. Гадаад орны шүүхийн шийдвэрүүд
- c. Олон улсын гэрээ
- d. Үндсэн хууль
- e. Оюун ухаан

72. Эрх зүйт хуулийн шинж

- a. Эрх зүйн шударга ёсны зарчим
- b. Эрх зүйн хувьд эрх тэгш чөлөөтэй байх зарчим
- c. Эрх чөлөөг түгээмэл тэгш хамгаалах зарчим
- d. Зохицуулалтын тэгш зарчим
- e. Зохицуулалтын захиран тушаах зарчим

73. Эрх зүйн бус акт

- a. Эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, харин ухуулсан, уриалсан, тайлбарлан таниулсан, мэдээлсэн, сануулсан, заавал биелэгдэх агуулгатай.
- b. Эрх зүйн үр дагавар үүсгэж, заавал биелэгдэх шинжийг агуулсан
- c. Эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, харин ухуулсан, уриалсан, тайлбарлан таниулсан, мэдээлсэн, сануулсан агуулгатай

74. Эрх зүйн акт ангилах шалгуур

- a. Эрх зүйн салбараар
- b. Эрх зүйн үр дагавар, үр нөлөөгөөр
- c. Хариуцлагаар нь
- d. Батлан гаргаж буй субъектээр нь
- e. Хууль зүйн хүчин чадлаар нь

75. Эрх зүйн актад үл хамаарах

- a. Үндсэн хууль
- b. Засгийн газрын тогтоол
- c. Ерөнхийлөгчийн зарлиг
- d. Засаг даргын захирамж
- e. Ердийн хууль

76. Монгол улсын эрх зүйн эх сурвалжийн эрэмбэ зөрчсөн эх сурвалж

- a. Үндсэн хууль
- b. Ерөнхийлөгчийн зарлиг
- c. Засгийн газрын тогтоол
- d. Хууль
- e. Монгол улсын олон улсын гэрээ

77. Орчин үеийн улс орнуудын эрх зүйн үндсэн эх сурвалж (үл хамаарахыг ол)

- a. Бүрэн эрх бүхий төрийн байгууллага, ард түмний санал, санал асуулгаар баталсан хууль
- b. Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт

- c. Шүүхийн хэвшүүлэн тогтоох хэм хэмжээ
- d. Шашны хэм хэмжээ
- e. Заншил, эдийн засаг, төрийн амьдралын практикт буй болсон зуршил
- f. Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, улс орнууд тогтоосон журмын дагуу соёрхон баталсан олон улсын гэрээ, пакт, конвенц

78. Эрх зүйн харилцаа бол (үл хамаарахыг ол)

- a. Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцаа
- b. Төрийн дээд албан тушаалтнуудын хоорондын харилцаа
- c. Төрийн албадлагаар хамгаалагдсан харилцаа
- d. Субъектив эрх ба хууль зүйн үүргийн нэгдэл

79. Эрх зүйн харилцааг чиг үүргээр нь хэрхэн ангилах вэ?

- a. Удирдах ба зохицуулах
- b. Хамгаалах ба бэхжүүлэх
- c. Зохицуулах ба хамгаалах
- d. Журамлах ба хамгаалах

80. Юуг шалгуур болгон эрх зүйн харилцааг харьцангуй ба туйлын гэж ангилдаг вэ?

- a. Зарчим
- b. Хэм хэмжээ
- c. Объект
- d. Субъект

81. Эрх зүйн харилцааны агуулга нь

- a. Гипотезид тусгалаа олно
- b. Диспозициор илэрнэ
- c. Санкцид агуулагдана
- d. Төрөөс хамаарна

82. Субъектив эрх бол:

- a. Гэрээнд заасан эрх
- b. Хуульд тусгагдсан эрх
- c. Үндсэн хуулиар баталгаажсан эрх
- d. Эрх зүйн харилцаанд оролцогчдын хууль зүйн боломжийн хэмжээ хязгаар

83. Субъектив эрхийг хамгаалагч нь

- a. Төр
- b. Төрийн бус байгууллага
- c. Хуульчид
- d. Улс төрчид

84. Хууль зүйн үүрэг бол:

- a. Хууль зүйн фактад үндэслэгдэнэ
- b. Зайлшгүй байх зан үйлийн хэмжээ хязгаар
- c. Ёс зүйн хэм хэмжээгээр илэрнэ
- d. Эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдоно

85. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар “Хүн бүр”

- a. Хуулийн этгээд мөн
- b. Эрх зүйн харилцааны субъект болно
- c. Эрх зүйн этгээд мөн
- d. Бие хүн мөн

86. “Эрх зүйн этгээд”, “Эрх зүйн харилцааны субъект” гэсэн ойлголт

- a. Агуулга, багтаамжийн хувь адил

- b. Эрх зүйн этгээд нь илүү өргөн хүрээтэй
- c. Эрх зүйн харилцааны субъект нь илүү өргөн хүрээтэй
- d. Хууль зүйн фактаас шууд хамаарна

87. Төр - эрх зүйн харилцааны субъект

- a. Болно
- b. Огт болохгүй
- c. Цөөн тохиолдолд байж болно
- d. Зөв хариулт алга байна

88. Эрх зүйн харилцааны субъект (үл хамаарахыг ол)

- a. Эрх зүйн харилцаанд оролцогч
- b. Эрх зүйн чадвар, чадамжтай иргэн
- c. Компани
- d. Ард түмэн

89. Эрх зүйн чадвар бол:

- a. Эрх эдэлж, үүрэг хүлээх ерөнхий чадвар
- b. Хууль зүйн боломж
- c. Субъектийн зан үйл (үйлдэл, эс үйлдэхүй)
- d. Хариуцлагыг биечлэн хариуцах онцгой чадвар

90. Хуулийн этгээдэд:

- a. Чадвар нь эхэлж үүснэ
- b. Чадамж нь эхэлж үүснэ
- c. Нэгэн зэрэг үүснэ
- d. Хууль зүйн фактаас хамаарна

91. Эрх зүйн зан үйл (үл хамаарахыг ол)

- a. Эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл
- b. Эрх зүйн дагуух үйлдэл
- c. Эрх зүйн эсрэг чиглэсэн эс үйлдэхүй
- d. Хуулиар хамгаалагдсан харилцаа

92. Эрх зүйн харилцааны объект:

- a. Харилцаанд өртөгдөж буй бүх зүйл
- b. Эрх зүйн хэмжээгээр хамгаалагдсан эрх ашиг
- c. Эд юмс
- d. Өмчлөх эрх

93. Объектийг нөлөөлөх шинжээр нь:

- a. Материаллаг ба материаллаг бус
- b. Эдийн ба эдийн бус
- c. Шууд ба шууд бус
- d. Байнгийн ба түр зуурын

94. Хууль зүйн факт бол

- a. Эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл
- b. Эрх зүйн харилцаа дуусгавар болох үндэслэл
- c. Эрх зүйн харилцаа өөрчлөгдөх үндэслэл
- d. Дээрхи бүгд зөв

95. Хууль зүйн фактийг хүсэл зоригийн шинжээр нь:

- a. Үйл явдал ба эрх зүйн зан үйл
- b. Үйлдэл ба эс үйлдэл
- c. Эрх зүйн дагуух ба эрх зүйн эсрэг
- d. Зөв хариулт алга байна

96. Үйл явдал бол

- a. Форс-мажор

- b. Гэмт хэрэг үйлдэх
- c. Хүний ухамсартай шууд холбоотой
- d. Хүүхэд төрөх

97. “Хууль зүйн факт” гэсэн ойлголт анхлан

- a. Гайн сурах бичигт тэмдэглэгдсэн
- b. Юстинианы хуульд тусгалаа олсон
- c. Савиньи бүтээлд тусгагдсан
- d. Ульпиан томъёолсон

98. Эрх зүйн харилцааны субъект

- a. Хуулийн этгээд
- b. Эрх зүйн харилцаанд оролцогч
- c. Эрх зүйн чадвар, чадамжтай иргэн
- d. Зөв хариулт байхгүй байна

99. Эрх зүйн зан үйл

- a. Хуулиар хамгаалагдсан харилцаа
- b. Эрх зүйн эсрэг чиглэсэн эс үйлдэл
- c. Эрх зүйн дагуух үйлдэл
- d. Эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл

100. Эрх зүйн хэм хэмжээний актын үйлчлэх хэмжээ хязгаар

- a. үйлчилбэл зохих нийгмийн харилцаа (үйлчлэх зүйл)
- b. хэм хэмжээний акт хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа (үйлчлэх цаг хугацаа)
- c. актын үйлчлэх нутаг дэвсгэр (үйлчлэх орон зай)
- d. хамаарагдах субъект (үйлчлэх этгээдийн хүрээ)
- e. дээрх бүгд багтана

101. Төрийн байгууллагын хооронд дахь эрх мэдлийн харилцаанд

- a. эд хөрөнгийн харилцааг зохицуулж буй эрх зүйн акт үүрэг гүйцэтгэхгүй
- b. эд хөрөнгөтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцааг зохицуулж буй хэм хэмжээний акт үүрэг гүйцэтгэнэ
- c. эд хөрөнгийн, эд хөрөнгөтэй холбоотой эд хөрөнгийн бус харилцааг зохицуулж буй хэм хэмжээний акт ямар ч үүрэг гүйцэтгэхгүй

102. Аль бодомж нь зөв бэ?

- a. Хүний хүсэл зоригоос гадуурхи үйл явдлын харилцаанд эрх зүйн актын үйлчлэл хамаарагдана
- b. Хүний хүсэл зоригоос гадуурхи үйл явдлын харилцаанд эрх зүйн актын үйлчлэл хамаарагдахгүй
- c. Хүний хүсэл зоригоос гадуурхи үйл явдлын харилцаанд эрх зүйн актын үйлчлэл зарим тохиолдолд

103. Эрх зүйн актын хүчин төгөлдөр болох үндэслэлд:

- a. актын хүчин төгөлдөр болох хугацааг шууд заасан бол тэр хугацаанаас
- b. албан ёсоор нийтэлснээс хойш хууль тогтоомжид заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд батлан гаргасан хугацаанаас шууд, эсвэл биелүүлбэл зохих субъектүүд хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно
- c. батлан гаргасан хугацаанаас шууд, эсвэл биелүүлбэл зохих субъектүүд хүлээн авсан өдрөөс хүчин төгөлдөр болно
- d. дээрх нийтлэг гурван үндэслэл багтана

104. Хүчин төгөлдөр актуудын үйлчлэх хугацааг дуусгавар болгох аргуудыг нэрлэнэ үү?

- a. эрх зүйн актын үйлчлэх хугацаа дууссан бөгөөд уг хугацааг дахин

сунгаагүй бол

- b. уг актыг эрх бүхий байгууллагаас хүчингүй болгосон
- c. уг актыг орлохуйц өөр акт батлагдаж гарсан тохиолдолд
- d. шинэ батлагдсан хуулийг дагаж мөрдөх

105. Хуулийг буцаан хэрэглэх тохиолдол

- a. хуучин хууль, хуульчилсан акт хүчин төгөлдөр бус болсон
- b. шинээр батлагдан гарсан хуулийн зарим зүйл, заалтуудад хуучин хуулийн нөхцөл байдал хүндэрсэн бол уг хуулийг хүчин төгөлдөр үед үүссэн харилцааг зохицуулахаар
- c. хуучин хууль нь илүү нарийн зохицуулсан бол

106. Хууль буцаан хэрэглэх асуудлыг

- a. шүүгч шийдвэрлэнэ
- b. хуулийн эрдэмтэд шийдвэрлэнэ
- c. зөвхөн хуулиар шийдвэрлэнэ
- d. хуулийг хэрэглэж буй албан тушаалтнууд шийдвэрлэнэ
- e. хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ

107. Хууль үйлчлэх орон зай нь

- a. тухайн улсын нутаг дэвсгэрээр тодорхойлогдоно
- b. төрийн бүрэн эрхт байдлаар тодорхойлогдоно
- c. төрийн эрх мэдлийг хуваарилсан байдлаар тодорхойлогдоно

108. Хуулийн үйлчлэх орон зайд хамаарахыг ол

- a. өөрийн нутаг дэвсгэр
- b. элчин сайдын яамны оршин байгаа гадаад улс дахь нутаг дэвсгэр
- c. задгай тэнгист яваа өөрийн онцлог тэмдэг бүхий хөлөг онгоц
- d. нисэх аппаратын кабин
- e. гадаад орны нутаг дэвсгэр

109. Хуулийн үйлчлэлд үл хамаарагдах субъектыг ол

- a. хүн амын тодорхой хэсэг
- b. албан тушаалтан
- c. гадаад орны дипломат ажилтан, элчин, консул
- d. цэрэг
- e. цагдаа

110. Монгол улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг

- a. тусгай хуулиар
- b. олон улсын гэрээ, хэлэлцээрээр
- c. өөрийн нь орны хуулиар
- d. уугуул орны нь хуулиар

111. Эрх зүйн этгээд нь

- a. хүн бүр
- b. албан ёсны байгууллага, аж ахуй нэгж
- c. хөрөнгө чинээгээрээ үүрэг хүлээх чадвар бүхий байгууллага
- d. шүүх, арбитрын үйл ажиллагаанд оролцох эрх бүхий байгууллага

112. Эрх зүйн үйлчлэлийн үр нөлөөг судладаг салбар ухаан

- a. харьцуулсан эрх зүй судлал
- b. социологийнэрх зүй
- c. системт хандлагын онол
- d. эрх зүйн философи
- e. криминологи

113. Үндсэн агуулгаараа эрх зүйн нэг төрлийн харилцааг

зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний нийлбэрийг нэрлэнэ үү?

- a. эрх зүйн заалт
- b. эрх зүйн институт
- c. эрх зүйн бүл

114. Эрх зүйн зохицуулалтын механизмын бүрдэл хэсэг нь (үл хамаарахыг ол)

- a. эрх зүйн хэм хэмжээ
- b. субъектив эрх
- c. хууль зүйн үүрэг
- d. хууль зүйн факт
- e. эрх зүйн хийдэл

115. Аль нь эрх зүйн зохицуулалтын гол үндэс вэ?

- a. эрх зүйн хэм хэмжээ
- b. субъектив эрх
- c. хууль зүйн үүрэг
- d. хууль зүйн факт
- e. эрх зүйн ухамсар

116. Эрх зүйн зохицуулалтын хамгийн гол арга

- a. эрх олгох
- b. зөвшөөрөл
- c. хориглох
- d. үүрэг болгох
- e. хариуцлага хүлээлгэх

117. Эрх зүйг хэрэгжүүлэх онцгой хэлбэр

- a. эрх зүйн хэм хэмжээг сахих
- b. эрх зүйн хэм хэмжээг биелүүлэх
- c. эрх зүйн хэм хэмжээг ашиглах
- d. эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх

118. Эрх зүйг хэрэглэх гэсэн ойлголт

- a. эрх зүйн этгээдийн эрхээ хамгаалж буй үйлдэл
- b. эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх төрийн үйл ажиллагаа
- c. эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг шүүхийн практикт хангаж буй төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа
- d. зөв хариулт алга байна

119. Эрх зүйг хэрэглэх субъект (үл хамаарахыг ол)

- a. шүүх
- b. Үндсэн хуулийн цэц
- c. прокурор
- d. төрийн албан тушаалтан
- e. иргэн

120. Эрх зүйг хэрэглэх зорилго

- a. эрх зүйг хэрэглэгчдийн хувийн хэрэгцээг хангах
- b. эрх, үүргээ хэрэгжүүлэх этгээдийн хэрэгцээг хангах
- c. нийгмийн ашиг сонирхол, хэрэгцээг хангах
- d. зөв хариулт байхгүй байна

121. Эрх зүйг хэрэглэх субъектын зорилт

- a. эрх зүйн хэм хэмжээг биелүүлэхийг албадах
- b. дэмжлэг үзүүлэх
- c. эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хариуцлага оногдуулах
- d. дээрх бүгд зөв

122. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх үндэслэл

- a. хууль тодорхой нөхцөл байдлыг тогтоох шаардлагатай бол
- b. хуулиар тодорхой нөхцөл байдлыг хянах шаардлагатай бол
- c. эрх, үүрэгтэй холбогдсон эрх зүйн маргаан үүссэн бол
- d. эрх зүйн зөрчил үүссэн бол
- e. дээрх хариулт бүгд зөв

123. Эрх зүйг хэрэглэх үе шат

- a. тухайн хэргийн бодит байдлыг тогтоох
- b. хэргийн хууль зүйн үндэслэлийг тогтоох
- c. хэргийг шийдвэрлэх
- d. дээрх бүгд зөв

124. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актын шинж (үл хамаарахыг ол)

- a. эрх бүхий байгууллагын тодорхой хэргийг шийдвэрлэсэн шийдвэр
- b. заавал биелүүлэх шинжтэй
- c. хуулийн тогтоосон хэлбэртэй
- d. нийгмийн харилцааг тусгайлан зохицуулсан шинжтэй
- e. зөв хариулт байхгүй байна

125. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актын онцлог ялгаа

- a. тодорхой субъектэд чиглэгддэг
- b. нийгмийн тодорхой харилцааг зохицуулдаг
- c. дахин хэрэглэгдэх тогтвортой шинжийг агуулдаг
- d. зөв хариулт байхгүй байна

126. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актанд тавигдах шаардлага

- a. хууль ёсны байх
- b. хууль зүйн үндэслэлтэй байх
- c. үр нөлөөтэй байх
- d. дээрх бүгд зөв

127. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актыг бүтээх субъект

- a. ерөнхийлөгч
- b. шүүгч
- c. прокурор
- d. төрийн албан тушаалтан
- e. иргэн

128. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэсэн актыг эрх зүйн зохицуулалтаар нь хэрхэн ангилдаг вэ?

- a. Үндсэн хуулийн эрх зүйн акт
- b. Захиргааны эрх зүйн акт
- c. Эрүүгийн эрх зүйн акт
- d. Процессын эрх зүйн акт
- e. дээрх хариулт бүгд зөв

129. Үндэсний эрх зүйн тогтолцооны бүрэлдэхүүн:

- a. Инфра бүтэц
- b. Эрх зүйн уламжлал
- c. Эрх зүйн бүл
- d. Эрх зүйн конвергенци

130. Эрх зүйн тогтолцоо хэмээх ойлголтын агуулга:

- a. Эрх зүйн гадаад хэлбэр
- b. Эрх зүйн институтүүдийн бүрдэл
- c. Эрх зүйн дотоод бүтэц

d. Хуульчилсан акт

131. Дараахь ойлголтуудаас аль нь өргөн агуулгатай вэ?

- a. Эрх зүйн зарчим
- b. Эрх зүйн тогтолцоо
- c. Инфра бүтэц
- d. Эрх зүйн институт

132. Инфра бүтэц

- a. Хууль зүйн боловсролын тогтолцоо
- b. Хууль зүйн кодификаци
- c. Төрийн байгууллагуудын бүтэц
- d. Хууль зүйн мэргэжлийн бүтэц

133. Ромын эрх зүйч Ульпиан эрх зүйн тогтолцоог хэрхэн хуваасан бэ?

- a. Эрүү, иргэн, төр захиргааны эрх зүй
- b. Нийтийн ба хувийн эрх зүй
- c. Эрүүгийн, хувийн, нийтийн эрх зүй
- d. Материаллаг ба процессийн эрх зүй

134. Салбар эрх зүйн агуулга:

- a. Эрх зүйн тогтолцооны дотоодод онцгойрон ялгарсан тодорхой төрлийн нийгмийн харилцааг зохицуулах нэг төрлийн эрх зүйн хэм хэмжээний нийлбэр
- b. Эрх зүйн тогтолцооны дотоодод онцгойрон ялгарсан тодорхой төрлийн нийгмийн харилцааг зохицуулах нэг төрлийн эрх зүйн харилцааны нийлбэр
- c. Дээрхи тодорхойлолтуудын аль нь ч биш

135. Эрүүгийн эрх зүйг нийтийн эрх зүйд хамруулах үндэслэл:

- a. Нийтлэг ёс суртахууны үнэт зүйлсийг хамгаалдаг
- b. Нийтийн эрх зүйн зохицуулах зүйл
- c. Гагцхүү нийтийн эрх зүйн зарчмууд үйлчилдэг
- d. Аль нь ч биш

136. Аль нь өргөн агуулгатай ойлголт вэ?

- a. Төрийн байгууллагуудын бүтэц
- b. Материаллаг эрх зүй
- c. Үндэсний эрх зүйн бүрдэл
- d. Хууль зүйн мэргэжлийн бүтэц

137. Процессийн эрх зүйн бүрдэл: (Үл хамаарахыг ол)

- a. Нотолгооны эрх зүй
- b. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй
- c. Эрх зүйг төрөлжүүлэхтэй холбогдсон харилцаа
- d. Арбитрын процесс

138. Эрх зүйн зохицуулах зүйл гэдэг нь:

- a. Эрх зүйгээр журамлагдаж буй нийгмийн харилцаа
- b. Нэг төрлийн шинжтэй нийгмийн харилцааг зохицуулдаг хууль зүйн хэрэглүүр
- c. Эрх зүйн тодорхой институтүүдийн хүрээнд буй нийгмийн харилцааны тодорхой нэг төрлийг зохицуулж буй эрх зүйн цэгцтэй хэм хэмжээний нийлбэр
- d. Аль нь ч биш

139. Нийгмийн харилцааг зохицуулагч хууль зүйн хэрэглүүр:

- a. Эрх зүйн зохицуулалтын арга

- b. Эрх зүйн зохицуулах зүйл
- c. Эрх зүйн институт
- d. Хууль зүйн мэргэжил

140. Эрх зүйн зохицуулалтын арга: (Үл хамаарахыг ол)

- a. Императив
- b. Диспозитив
- c. Урамшуулах арга
- d. Сайшаах арга

141. Эрх зүйн харилцаанд оролцогч талуудын зөвшилцөх, эрх тэгш боломж олгоход чиглэсэн зохицуулалтын арга:

- a. Императив
- b. Урамшуулах арга
- c. Зөвлөмж болгосон арга
- d. Диспозитив

142. Хувийн эрх зүйг тодорхойлох онцлог шинж:

- a. Диспозитив хэм хэмжээ
- b. Харилцаанд оролцогч субъектүүдийн эрх тэгш боломж
- c. Нэг талын хүсэл зориг давуу илэрдэг
- d. Императив арга

143. Нийтийн эрх зүйн түгээмэл шинж:

- a. Нэг талын хүсэл зориг давуу илэрдэг
- b. Нийтлэг ёс суртахууны үнэт зүйлсийг хамгаалдаг
- c. Субъектүүдийн үүрэгт хувийн хариуцлага хүлээлгэдэг
- d. Диспозитив хэм хэмжээ

144. Эдгээрээс аль материаллаг эрх зүй вэ? (Үл хамаарахыг ол)

- a. Өв залгамжлалын эрх зүй
- b. Өмчийн эрх зүй
- c. Нотолгооны эрх зүй
- d. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй

145. Хөдөлмөр, нийгэм хангамжийн эрх зүй нь:

- a. Хувийн эрх зүй
- b. Нийтийн эрх зүй
- c. Холимог эрх зүй
- d. Аль нь ч биш

146. Аль эрх зүйг “цэвэр” эрх зүй гэдэг вэ?

- a. Хувийн эрх зүй
- b. Нийтийн эрх зүй
- c. Холимог эрх зүй
- d. Үндсэн хуулийн эрх зүй

147. Хувийн эрх зүй:

- a. Худалдааны эрх зүй
- b. Санхүүгийн эрх зүй
- c. Газрын эрх зүй
- d. Хот байгуулалтын эрх зүй

148. Эрх зүйн бүл:

- a. Түгээмэл шинж, чиг хандлагын үндсэн дээр хуваагдсан эрх зүйн тогтолцооны нийлбэр
- b. Онцгойрох эрх зүйн харилцааны нийлбэр
- c. Эрх зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, эрх зүйн орчин, үзэл суртлаар хүмүүсийн ухамсарт гүн гүнзгий шингэж нөхцөлдсөн харилцааны цогц

d. Дээрхи бүгд

149. Эрх зүйн тогтолцоог процессийн эрх зүйн зарчмыг шалгуур болгон хэрхэн ангилдаг вэ?

- a. Мэтгэлцэх ба хянах тогтолцоо
- b. Мөрдөх ба мэтгэлцэх тогтолцоо
- c. Өрнийн ба социалист эрх зүйн тогтолцоо
- d. Дээрхи бүгд зөв

150. Өрнийн эрх зүйн бүлийн онцлог: (Үл хамаарахыг ол)

- a. Католик сүм хийдийн эрх зүйн хүчтэй нөлөө
- b. Жам ёсны эрх зүй философи
- c. Шүүхийн мэтгэлцэх тогтолцоо
- d. Ромын хувийн эрх зүйн нөлөө

151. Шашны эрх зүй:

- a. Өрнийн эрх зүй
- b. Хуурмаг өрнийн эрх зүй
- c. Скандинавын эрх зүй
- d. Каноны эрх зүй

152. Социалист эрх зүйн тогтолцооны мөн чанар:

- a. Хувийн эрх зүйг хамгаалах
- b. Татварын цээрлүүлэх бодлого
- c. Нийгмийн халамжийг үгүйсгэх
- d. Нийтийн эрх зүйн нөлөөг ихэсгэх

153. Эрх зүйн тогтолцоог бүл болгон ангилах шалгуур: (Үл хамаарахыг ол)

- a. Эрх зүйн үзэл суртал
- b. Эрх зүйн инфра бүтэц
- c. Эрх зүйн хэм хэмжээ
- d. Эрх зүйн арга зүй

154. Аль бодомж зөв бэ?

- a. Өрнийн эрх зүй нь эрх зүйт төртэй салшгүй холбоотой
- b. Өрнийн эрх зүй төлөвшихөд каноны эрх зүй хүчтэй нөлөөлсөн
- c. Социалист эрх зүй нь өрнийн эрх зүй мөн
- d. Дорнын эрх зүй нь өрнийн эрх зүйд хүчтэй нөлөөлсөн

155. Эрх зүйт төрийн зарчмаар шалгуур хийвэл эрх зүйн тогтолцоог

- a. өрнийн ба хуурмаг өрнийн, өрнийн бус
- b. нийтлэг, иргэнлэг, социалист
- c. шашинт, шашинт бус
- d. уламжлалт, улс төржсөн, мэрэгшсэн гэж ангилна

156. Шүүхийн сэтгэлгээний тогтолцоо нь индуктив байдаг эрх зүйн тогтолцоо

- a. Социалист эрх зүйн бүл
- b. Иргэнлэг эрх зүйн бүл
- c. Нийтлэг эрх зүйн бүл

157. Олон улсын хувийн эрх зүй нь

- a. олон улсын эрх зүйн нэг салбар
- b. үндэсний эрх зүй дэх иргэний эрх зүйн нэг салбар
- c. эдгээрийн аль алиных нь шинжийг агуулсан бие даасан салбар

158. Хууль зүйн стиль нь

- a. эрх зүйн аргуудад илүү хамаатай
- b. эрх зүйн үзэл баримлалд илүү хамаатай

с. эрх зүйн соёлд илүү хамаатай байдаг

159. Английн эрх зүйд завал биелэгдэх шинжтэй эх сурвалжид

- a. Үндсэн хууль
- b. шүүхийн прецедент
- c. обитер диктум багтана

160. Харьцуулсан эрх зүй судлаачдын маргаан үүсэгдэггүй асуудал нь

- a. харьцуулсан эрх зүй нь салбар эрх зүй мөн эсэх
- b. харьцуулсан эрх зүй нь бие даасан шинжлэх ухаан мөн эсэх
- c. аль нь ч биш

161. Хувийн эрх зүйг дотор нь худалдааны ба иргэний гэж хуваадаг үндэсний эрх зүй

- a. Германы эрх зүй
- b. Английн эрх зүй
- c. Оросын эрх зүй
- d. Монголын эрх зүй

162. Эрх зүйн инфра бүтэц (үл хамаарахыг ол)

- a. хууль зүйн боловсролын тогтолцоо
- b. хууль зүйн мэрэгжлийн бүтэц
- c. материаллаг эрх зүй
- d. хууль зүйн техник

163. Өрнийн эрх зүй дотроос эрх зүйг нийтийн ба хувийн гэж хуваахыг хүлээн зөвшөөрдөггүй үндэсний эрх зүй

- a. Английн эрх зүй
- b. Германы эрх зүй
- c. Скандиновын орнуудын эрх зүй
- d. Францын эрх зүй

164. Хууль тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгох орчин үеийн арга (үл хамаарахыг ол)

- a. эрх зүйг зээлдэн хэрэглэх
- b. эрх зүйг уламжлан шилжүүлэх
- c. экспортлох
- d. импортлох

165. Эрх зүйн соёлыг зээлдэн авч нутагшуулах нь

- a. Эрх зүйн конвергенц
- b. Эрх зүйн рецепци
- c. Эрх зүйн глобальчлал
- d. Зөв хариулт байхгүй байна

166. Эрх зүйн рецепци хийхэд анхаарах зүйл (үл хамаарахыг ол)

- a. нутагшиж чадах
- b. үндэсний онцлог
- c. эрх зүйн тогтолцоо
- d. эрх зүйн зорилго

167. Хуулийн гол үзэл баримтлалыг нь зээлдэн нутагшуулах нь:

- a. хуулийг хөрвүүлэн шилжүүлэн авч байгаа хэлбэр
- b. хуулийг бүхэлд нь шилжүүлэн авч байгаа хэлбэр
- c. хуулийг гол санаагаар нь шилжүүлэн авч байгаа хэлбэр
- d. хуулийг залгамжилан шилжүүлэн авч байгаа хэлбэр

168. Хуулийг бүхэлд нь рецепцилэн авахын эерэг тал (үл хамаарахыг ол)

- a. хуулийн тогтолцоо эвдэрдэггүй
- b. логик бүтэц нь алдагддаггүй байх
- c. шууд нутагших бололцоотой, тохирохуйц байх
- d. залгамж холбоо, хэрэгжих механизм сайн байх

169. Эрх зүйн янз бүрийн тогтолцоо өөр хоорондоо ойртох үйл явц

- a. Интеграци
- b. эрх зүйн конвергенц
- c. эрх зүйн рецепци
- d. эрх зүйн глобальчлал

170. Эрх зүйн конвергенц гэсэн нэр томъёо

- a. конвергенцийн онолоос үүсэлтэй
- b. рецепцийн онолоос үүсэлтэй
- c. соёл иргэншлийн онолоос үүсэлтэй
- d. зөв хариулт байхгүй байна

171. Аль тохиолдолд хуульчийн (мэргэжлийн) эрх зүйн ухамсрын өндөр түвшинг шаардах вэ?

- a. хуулийг сахин биелүүлэхэд
- b. хуулийг хэрэгжүүлэхэд
- c. хуулийг хэрэглэхэд
- d. хуулийг тайлбарлахад

172. Эрх зүйн ухамсар нь

- a. бодит ахуйн тусгал
- b. эрх зүйн бодит байдлын тусгал
- c. хуулийн тусгал
- d. эрх зүйн үзэл суртал
- e. эрх зүйн зан үйл

173. Эрх зүйн ухамсрыг агуулгаар нь хэрхэн ангилах вэ?

- a. эрх зүйн үзэл суртал
- b. эрх зүйн сэтгэл судлал
- c. эрх зүйн мэдлэг
- d. эрх зүйн чадамж
- e. эрх зүйн зан үйл

174. Эрх зүйн ухамсрын бүтцийн ангилалд

- a. энгийн
- b. онолын
- c. мэргэжлийн
- d. шүүгчдийн
- e. залуусын гэж ангилна

175. Эрх зүйн соёлыг хэмжих түвшин

- a. хүн амын эрх зүйн ухамсрын
- b. эрх зүйн үйл ажиллагааны хөгжлийн
- c. хууль тогтоомжийн хөгжлийн
- d. хууль зүйн техникийн
- e. төрийн байгууллагуудын үйл ажиллагааны түвшин

176. Эрх зүйн сэтгэл судлал нь

- a. эрх зүйн талаарх онолын цэгцтэй мэдлэг
- b. мэргэжлийн эрх зүйн ухамсар
- c. эрх зүйн үзэгдэл харилцааг мэдрэх мэдрэмж
- d. эрх зүйн үзэл суртал

177. Эрх зүйн ухамсрын үндсэн чиг үүрэг (үл хамаарахыг ол)

- a. хууль тогтоох
- b. танин мэдэх
- c. үнэлж цэгнэх
- d. зохицуулах

178. Эрх зүйн соёлын агуулгыг нээн илэрхийлэгч вэ?

- a. эрх зүйн мэдлэг
- b. эрх зүйн хүмүүжил
- c. эрх зүйн ухамсар
- d. эрх зүйн идэвхитэй байр суурь
- e. үйл ажиллагааны сэдэл

179. Эрх зүйн ухамсар төлөвшихөд нөлөөлөх хүчин зүйлсэд үл хамаарахыг ол

- a. улс төрийн ухамсар
- b. шашин
- c. ёс суртахуун
- d. цаг агаар
- e. нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал

180. Аль бодомж нь зөв бэ?

- a. Эрх зүйн онол, эрх зүйн үзэл суртал хоёр шууд хамааралтай
- b. Эрх зүйн онол, эрх зүйн үзэл суртал хоёр ямар ч хамааралгүй
- c. Эрх зүйн онол, эрх зүйн үзэл суртал хоёр шууд бус хамааралтай

181. Эрх зүйг үгүйсгэх үзлийн мөн чанар

- a. Эрх зүйн дэг журмыг хэтрүүлэн үнэлэх
- b. Эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон дэг журмыг туйлшруулан үнэлэх
- c. Эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон дэг журмыг үл хүндэтгэсэн байдлаар буюу сөрөг байдлаар үгүйсгэн үзэх
- d. Зөв хариулт алга байна

182. “Монголын хууль гурав хоног” гэсэн зүйрлэл аль үзэлтэй холбоотой вэ?

- a. Эрх зүйг туйлшруулах үзэл
- b. Эрх зүйг үгүйсгэх үзэл
- c. Эрх зүйг дээдлэх үзэл
- d. Эрх зүйг хэтрүүлэх үзэл

183. Эрх зүйг үгүйсгэх үзлийг даван туулах арга зам

- a. Нийгэмд ёс суртахууныг төлөвшүүлэх
- b. Хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх
- c. Хуулийн байгууллага, хууль зүйн мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх
- d. Зөв хариулт байхгүй байна

184. Эрх зүйг үгүйсгэх үзлийн эх сурвалж (үл хамаарах)

- a. Хуулийг үл биелүүлэх
- b. Хуулийг үл тоомсорлох
- c. Төрийн байгууллагад хайхрамжгүй хандах
- d. Улс төрийн идэвхигүй байдал

185. Эрх зүйн зөрчил нь:

- a. хууль ёсны зан үйл
- b. хууль ёсны бус зан үйл
- c. гэм буруутай үйлдэл, эс үйлдэл
- d. үйлдэл, эс үйлдэл

186. Эрх зүйн зөрчлийн шинж (үл хамаарахыг ол)

- a. хууль бус үйл ажиллагаа

- b. гэм буруутай үйл ажиллагаа
 - c. хуулийг үл тоомсорлосон байх -
 - d. нийгэмд хор аюултай байх
 - e. хууль тогтоомжинд заагдсан шийтгэлтэй байх
- 187. Хүний хүсэл зоригоос үл шалтгаалах үйл явдал (казус) болон бодол санаа, хүсэл мөрөөдөл эрх зүйн зөрчил болох уу?**

- a. болно
- b. болохгүй
- c. зарим тохиолдолд болно

188. Зөрчлийн шинжийн онол нь

- a. объект, субъект, объектив тал, субъектив тал
- b. гэм буруу, хор уршиг, нийгэмд аюултай, хуульд заагдсан гэсэн ангиллыг үүсгэнэ
- c. эдгээрийн аль нь ч биш

189. Эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүн

- a. хууль ёсны бус зан үйлийн дотоод шинж тэмдгийг илэрхийлсэн ойлголт
- b. хууль ёсны бус зан үйлийн гадаад шинж тэмдгийг илэрхийлсэн ойлголт
- c. хууль ёсны бус зан үйлийн дотоод хийгээд гадаад шинж тэмдгийг илэрхийлсэн ойлголт
- d. Зөв хариулт алга байна

190. Аль нь эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүнд үл хамаарах вэ?

- a. субъект
- b. субъектив эрх
- c. объект
- d. субъектив тал
- e. объектив тал

191. Эрх зүйн зөрчлийн субъектэд хамаарагдах шинж (үл хамаарахыг ол)

- a. эрх зүйн чадамжтай байх
- b. эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн байх
- c. эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан байх
- d. гэм буруутай байх
- e. хариуцлага заавал хүлээх

192. Эрх зүйн зөрчлийн субъектийн ангилал

- a. нийтлэг субъект
- b. онцгой субъект
- c. тусгай субъект
- d. ерөнхий субъект

193. Эрх зүйн зөрчлийн объект

- a. гэмт халдлагаас хамгаалагдаж байгаа эрх зүйн харилцаа
- b. гэмт зан үйлийн хандлага чиглэсэн нийгмийн харилцаа
- c. гэмт зан үйлийн хандлага чиглэсэн тодорхой нэг төрлийн харилцаа
- d. зөв хариулт байхгүй байна

194. Эрх зүйн зөрчлийн объектын ангилал (үл хамаарахыг ол)

- a. ерөнхий объект
- b. нийтлэг объект
- c. төрлийн объект
- d. нэг бүрчилсэн объект
- e. шууд объект

195. Эрх зүйн зөрчлийн объектын нэмэгдэл шинж

- a. эдийн баялаг
- b. халдлагын зүйл
- c. эдийн бус баялаг
- d. нийгмийн хор аюул
- e. хууль бус үйлдэл

196. Эрх зүйн зөрчлийн субъектээс өөрийн гэмт зан үйл, түүний үр дагаварт хандах хандлага нь

- a. субъектив талыг илэрхийлсэн ойлголт
- b. объектив талыг илэрхийлсэн ойлголт
- c. субъектив талын нэмэгдэл шинжийг илэрхийлсэн ойлголт
- d. объектив талын нэмэгдэл шинжийг илэрхийлсэн ойлголт

197. Эрх зүйн зөрчлийн субъектив талд хамаарах шинжийг тодорхойл (үл хамаарахыг ол)

- a. цаг хугацаа
- b. нөхцөл байдал
- c. гэм буруу
- d. зорилго
- e. хууль бус үйлдэл

198. Эрх зүйн зөрчлийн субъектив талын нэмэгдэл шинж

- a. сэдэлт
- b. халдлагын зүйл
- c. зорилго
- d. нийгмийн хор аюул
- e. гэм буруу

199. Эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн, нийгэмд хор аюултай зан үйлийг илэрхийлсэн ойлголт

- a. субъектив талыг илэрхийлсэн ойлголт
- b. объектив талыг илэрхийлсэн ойлголт
- c. субъектив талын нэмэгдэл шинжийг илэрхийлсэн ойлголт
- d. объектив талын нэмэгдэл шинжийг илэрхийлсэн ойлголт

200. Аль нь объектив талын элементэд хамаарах вэ? (үл хамаарахыг ол)

- a. үйлдэл, эс үйлдэл
- b. гэм хор, хор уршиг
- c. шалтгаант холбоо
- d. гэм буруу

201. Эрх зүйн зөрчлийн объектив талын бүрэлдэхүүний шинж

- a. орон зай
- b. сэдэлт
- c. цаг хугацаа
- d. санаа
- e. зорилго

202. Эрх зүйн зөрчлийг нийгэмд учруулсан хор хохирлын шинжээр хэрхэн ангилдаг вэ?

- a. гэмт хэрэг
- b. иргэний хэрэг
- c. сахилгын зөрчил
- d. захиргааны зөрчил
- e. гэмт хэргийн бус эрх зүйн зөрчил

203. Хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл (үл хамаарахыг ол)

- a. эрх зүйн хэм хэмжээ
- b. эрх зүйн зөрчлийн факт
- c. эрх зүйн ухамсар
- d. эрх зүйг хэрэглэх акт

204. Хууль зүйн хариуцлага нь дараах шинжийг өөртөө агуулна

- a. эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн байх
- b. төрийн албадлага хэрэглэх
- c. хууль зүйн факт дуусгавар болсон байх
- d. зөрчигдсөн эрхийг сэргээн хангах
- e. эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох

205. Хууль зүйн хариуцлагын чиг үүрэг (үл хамаарахыг ол)

- a. урьдчилан сэргийлэх
- b. хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх
- c. зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх
- d. учруулсан хохирлыг арилгах
- e. нийгэмд дэг журам тогтоох

206. Хууль зүйн хариуцлагын харилцааны үндсэн субъект

- a. эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд ба төр
- b. гэмт хэрэгтэн ба төрийн нэрийн өмнөөс санкци хэрэглэх эрх мэдэл бүхий байгууллага
- c. хөдөлмөрийн сахилга алдсан этгээд ба шүүх
- d. эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээд ба төрийн нэрийн өмнөөс санкци хэрэглэх эрх мэдэл бүхий байгууллага

207. Хууль зүйн хариуцлага хүлээж буй этгээдийн субъектив эрх:

- a. өөрийн үйлдсэн үйлдэл, эс үйлдэлд оногдуулж буй шийтгэл гаргасан зөрчилд тохирсон эсэхийг шаардах
- b. хууль зүйн туслалцаа авах
- c. ялыг ялгамжтай оногдуулахыг хүсэх
- d. хуульд нийцсэн байхыг шаардах
- e. хариуцлагыг хөнгөрүүлж үзэхийг хүсэх

208. Хууль зүйн хариуцлага хүлээлгэх журмыг:

- a. эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хэм хэмжээгээр тогтооно
- b. хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээгээр тогтооно
- c. иргэний эрх зүйн хэм хэмжээгээр тогтооно
- d. иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээгээр тогтооно
- e. захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр тогтооно

209. Хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд баримтлах зарчим (үл хамаарахыг ол)

- a. шударга ёсны
- b. гэм буруугүйд тооцох
- c. хууль дээдлэх
- d. үндэсний эв нэгдлийг хангах
- e. ялгамжтай хандах

210. “Хуульд заагаагүй бол гэмт хэрэг гэж үзэхгүй” (nullum crimen sine lege) гэсэн үндэслэл аль зарчимд хамаарах вэ?

- a. шударга ёсны зарчим
- b. гэм буруугүйд тооцох зарчим
- c. эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэлд нь хариуцлага хүлээлгэх

d. хууль дээдлэх

e. ялыг ялгамжтай оногдуулах

211. Хууль зүйн хариуцлагын төрөл (үл хамаарахыг ол)

a. иргэний эрх зүйн хариуцлага

b. эрүүгийн хариуцлага

c. захиргааны хариуцлага

d. хөдөлмөрийн хариуцлага

e. сахилгын хариуцлага

212. “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэсэн үндэслэл аль зарчимд хамаарах вэ?

a. шударга ёны зарчим

b. гэм буруугүйд тооцох зарчим

c. гэм буруутай үйлдэл, эс үйлдэлд нь хариуцлага хүлээлгэх

d. хууль дээдлэх

e. ялыг ялгамжтай оногдуулах

213. “Хуульгүйгээр ямар ч шийтгэл байх ёсгүй” (nulla poena sine lege) гэсэн үндэслэл аль зарчимд хамаарах вэ?

a. эрүүгийн хууль тогтоомжийг буцаан хэрэглэхийг хориглох

b. гэм буруугүйд тооцох зарчим

c. гэм буруутай үйлдэл, эс үйлдэлд нь хариуцлага хүлээлгэх

d. ялыг ялгамжтай оногдуулах

214. Хуулийн агуулгыг нээн илэрхийлэхтэй холбогдон гарах ойлголт:

a. Хууль зүйн системчлэл

b. Хууль тогтоох

c. Хуулийн бичвэр

d. Хуулийн кодификаци

215. Хуулийг боловсруулах, хэлбэршүүлэх, болон системчлэх арга, хэрэгслийн нийлбэр цогц гэсэн агуулга:

a. Хууль зүйн техник

b. Хуулийн бүрдүүлэлт

c. Хуулийн кодификаци

d. Хууль батлах

216. Хууль зүйн техникийн агуулга:

a. Эрх зүйн хэм хэмжээг бүтээх зарчим

b. Хууль зүйн техникийн журам

c. Хуулийг хэрэгжүүлэх арга, хэрэгсэл

d. Аль нь ч биш

217. Хуулийн нэгж илэрхийлэл:

a. Зарчим

b. Зүйл

c. Заалт

d. Горим журам

218. Иш татсан зүйл гэдэг нь:

a. Хуулийн заалтыг шууд заах

b. Өөр эх сурвалжид хандах

c. Олон улсын гэрээг хэрэглэхээр заах

d. Аль нь ч биш

219. Хуулийн техникийн шаардлага: (Үл хамаарахыг ол)

- a. Хэм хэмжээ нь нийтлэг нөхцлөөр илрэх
- b. Хэм хэмжээ нь агуулгатай байх
- c. Үндсэн хэм хэмжээндээ захирагдсан байх
- d. Нэр томъёо ойлгомжтой байх

220. Аль нь зөв бодомж вэ?

- a. Хууль зүйн техник нь эрх зүйг боловсронгуй олгодог
- b. Хууль зүйн техникээр “амьд” эрх зүйг танддаг
- c. Эрх зүйн системчлэл нь хууль зүйн техникийг нөхцөлдүүлдэг
- d. Бүгд зөв

221. Аль нь өргөн агуулгатай вэ?

- a. Хууль зүйн бүтэц
- b. Хууль зүйн нэр томъёо
- c. Хууль зүйн техник
- d. Хуулийн агуулгыг нээх арга

222. Эрх зүйн кодификацийн агуулга:

- a. Хуулийг төрөлжүүлэн нэгтгэх
- b. Хуулийг төрөлжүүлэн хуульчлах
- c. Эрх зүйг задлан хөгжүүлэх
- d. Хуулийг системчлэх

223. Хууль зүйн нэр томъёо нь:

- a. Нийтэд ойлгомжтой байна
- b. Хууль зүйн агуулгаа бүрэн илэрхийлж чадахуйц байна
- c. Бие биендээ хамааралгүй байна
- d. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байна.

224. Хууль зүйн нэр томъёонд тавигдах шаардлага:

- a. Уран зохиолын агуулгатай байж болно
- b. Хоёрдмол санааг агуулахгүй байх
- c. Энгийн, ойлгомжтой байх
- d. Сонирхолтой байх ёстой

225. Аль нь зөв бодомж вэ?

- a. Хууль зүйн хэл нь нийтлэг хэл зүйд захирагдана
- b. Хууль зүйн хэл тусгай нэр томъёогоор онцлогтой
- c. Хууль зүйн техник хууль зүйн хэлийг нөхцөлдүүлнэ
- d. Хууль зүйн хэл нь энгийн хүмүүст зориулагдана

226. Эрх зүйн хэм хэмжээний актыг зохих түвшинд нэгтгэж эмхтгэл болгон гаргах замаар нэгтгэн төрөлжүүлэх ажиллагаа:

- a. Хууль зүйн кодификаци
- b. Хууль зүйн инкорпораци
- c. Хууль тогтоомжийн консолидаци
- d. Хууль тогтоомжийн бүртгэл

227. Хууль зүйн инкорпорацийн гол агуулга: (Үл хамаарахыг ол)

- a. Эрх зүйн зохицуулалтын агуулгад өөрчлөлт оруулахгүй
- b. Эрх зүйн зохицуулалтын агуулгад өөрчлөлт оруулдаг
- c. Эмхтгэлд орж буй актын агуулгыг хөнддөггүй
- d. Аль нь ч биш

228. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн хэм хэмжээний олон тооны актуудыг хууль тогтоомжийн нэг томоохон акт болгон хянан төрөлжүүлэх ажиллагаа:

- a. Хууль тогтоомжийн бүртгэл
- b. Хууль тогтоомжийн кодификаци

- c. Хууль тогтоомжийн инкорпораци
- d. Хууль тогтоомжийн консолидаци

229. Нэг төрлийн буюу ойролцоо шинжтэй нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээнүүдийг нэгтгэн системчилсэн хуульчилсан акт:

- a. Кодификаци
- b. Кодекс
- c. Органик хууль
- d. Онцгой хууль

230. Кодексийн үндсэн шинж:

- a. Хэм хэмжээтэй байх
- b. Системчлэгдсэн байх
- c. Тоо бүртгэлд хамрагдсан байх
- d. Хэм хэмжээ нь энгийн, ойлгомжтой байх

231. Эрх зүйн төрөлжүүлэлт:

- a. Хуулийн оюутанд судлахад төвөгтэй
- b. Хуулийг логик, системлэг чанартай болгодог
- c. Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг дээшлүүлдэг
- d. Иргэний эрх зүйн соёлыг дээшлүүлдэг

232. Зөв бодомжийг ол

- a. Хууль зүйн кодификаци нь хуулийн бүтцийг алдагдуулдаг
- b. Хууль зүйн кодификаци нь хуулийг тодорхой болгодог
- c. Кодекс нь парламентын үүргийг нэмэгдүүлдэг
- d. Дээрхи бүгд зөв

233. Үндсэн хуулиас шууд эх авсан хууль:

- a. Кодекс
- b. Органик хууль
- c. Хууль
- d. УИХ-ын тогтоол

234. Иргэний хууль нь:

- a. Органик хууль
- b. Кодекс
- c. Хууль
- d. Хувийн эрх зүйд давуу чанартай хууль

235. Техник талаас сайн хууль гэдэг нь:

- a. Агуулга нь эрх зүйн шинэтгэлийн бодлогод нийцсэн
- b. Үг, үсгийн алдаа байхгүй
- c. Бүтцийн хувьд зөв системчлэгдсэн
- d. Хуулийн үйлчлэлийн хүрээг тодорхойлсон

236. Аль нь өргөн агуулгатай вэ?

- a. Хуулийн бүлэг
- b. Хуулийн хэсэг
- c. Хуулийн зүйл
- d. Нийтлэг үндэслэл

237. Бланкет зүйлийн агуулга:

- a. Хэрэглэх зүйлийг нөхөн бичсэн байна
- b. Хэрэглэх зүйлийг орхиж, шүүгчид өргөн боломж олгоно
- c. Хандах өөр эх сурвалжийг заасан байна
- d. Хуулийн зохицуулалтгүй бол өөр хууль хэрэглэх

238. Эрх зүйн хийдэл гэх ойлголтыг байх ёсгүй гэж үздэг эрх зүйн

бүл

- a. нийтлэг эрх зүйн бүл
- b. иргэнлэг эрх зүйн бүл
- c. шашинт эрх зүйн бүл
- d. социалист эрх зүйн бүл

239. Эрх зүйн хийдэл гэх ойлголт нь дараах онолд хамаатай /үл хамаарахыг ол/

- a. хууль тогтоох онол
- b. процедурын онол
- c. хууль дээдлэх онол
- d. социалист эрх зүйн онол

240. "Хууль тогтоомж" гэсэн ойлголт нь багтаамжаараа

- a. парламентаас баталсан эрх зүйн баримт бичгийн хүрээнд
- b. шүүхэд хэрэглэгддэг эх сурвалжийн хүрээнд
- c. хууль тогтоох болон гүйцэтгэх, шүүх эрх мэдлээс гаргаж буй бүх баримт бичгийн хувьд
- d. хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн баримт бичгүүдийн хувьд ойлгогдоно

241. Эрх зүйн хэм хэмжээг уг хэм хэмжээг тогтоогчийн зүгээс тайлбарладаг тайлбарыг

- a. аутентик тайлбар
- b. казуаль тайлбар
- c. үгчилсэн тайлбар
- d. телеологийн тайлбар

242. Хууль зүйн баримт бичгийн реквизитүүд гэдэг нь

- a. баримт бичигт тавигдах шаардлагын бүрдүүлбэр
- b. баримт бичгийн хэлбэрийн шаардлага
- c. баримт бичгийн дотоод бүтцийг илэрхийлсэн ойлголт

243. Эрх зүйн актын агуулгыг тайлбарлах багтаамж

- a. хэм хэмжээ тогтоосон баримт бичиг төдий явцуу агуулгатай
- b. хэм хэмжээ тогтоосон болон, тогтоогоогүй баримт бичиг зэргийг багтаах өргөн агуулгатай
- c. эрх зүйн баримт бичгээс гадна өргөн агуулгатай
- d. эдгээрийн аль нь ч биш

244. Хууль тайлбарлахад баримтлах үндсэн аксиомууд

- a. хүний эрхийг баталгаажуулсан ба дээшлүүлсэн тайлбар давуу эрхтэй байхыг чухалчилах
- b. адил хүчинтэй эрх зүйн баримт бичигт зөрчилдөөн үүсвэл тэдгээрээс давуу хүчин чадалтай баримт бичигт үндэслэх
- c. эрх зүйн баримт бичиг гарах үеийн түүхэн нөхцөл байдал, баталсан үндэслэлийг чухалчилах

245. Эрх зүйн либерал тайлбар гэдэг нь

- a. хэм хэмжээг хөгжлийн түвшинд нь үнэлэн тайлбарлах явдал
- b. хэм хэмжээг баталсан цаг үеийн үндэслэлд нь үнэлэн тайлбарлах явдал
- c. эдгээрийн аль нь ч биш

246. Хууль хэрэглэх гэдэг нь

- a. хууль тайлбарлахтай холбоотой
- b. шүүхээс эх сурвалж хэрэглэх болон түүний процедуртай холбоотой
- c. иргэд байгууллага хууль сахин биелүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой

ойлголт

247. Албан ёсны тайлбарт үл хамаархыг ол

- a. аутентик
- b. номлолын
- c. казуаль

248. Тайлбарын аргачлалд үл хамаархыг ол

- a. хэл зүйн
- b. логикийн
- c. системчилсэн
- d. аутентик

249. Эрх зүйн тайлбар нь

- a. хууль зүйн шинжлэх ухаан, эрх зүйн соёл, шүүхийн практик зэргийг нэгтгэх боломжийг
- b. хуулийг нэг мөр ойлгож, эрх зүйн хийдлийг даван туулах боломжийг
- c. эрх зүй өөрөө хөгжиж, эрүүлжих боломжийг илүүтэй олгодог

250. Хууль хэрэглэх тайлбар нь

- a. хууль тогтоох эрх бүхий байгууллага бусад байгууллагаас гаргасан эрх зүйн хэм хэмжээг тайлбарлаж буй тайлбар
- b. тухайн тайлбарлаж буй хэм хэмжээг батлан гаргасан байгууллага өөрөө хийж буй тайлбар
- c. шүүх эрх мэдлийн байгууллага хэм хэмжээний зохих хэсгийг тайлбарлаж байгаа тайлбар
- d. зөвхөн тодорхой тохиолдолд тухайн хэсэгт хамаатай нэг удаагын шинжтэй тайлбар мөн

Эрх зүйн онолын тест – 2009

/НЭМЭГДСЭН – 2009.04.09/

1. Хуулийн төслийн төрөл
 - a. Анхдагч хуулийн төсөл
 - b. Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл
 - c. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл
 - d. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
 - e. Хууль хүчингүй болгох хуулийн төсөл
2. Хуулийн төсөлд тавих нийтлэг шаардлага
 - a. Хуулийг чанд сахих
 - b. Үндсэн хуульд нийцсэн байх
 - c. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдөхгүй байх
 - d. Үндсэн хуульд ёсыг баталгаажуулах
 - e. Хэм хэмжээ тогтоогоогүй буюу тунхагласан шинжтэй заалтыг тусгахгүй байх
3. Тогтоолын төсөлд тавих шаардлага
 - a. Үндсэн хуульд нийцсэн байх
 - b. Хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх
 - c. Хуулийн заалтыг давтахгүй байх
 - d. Хариуцлагын хэм хэмжээг заахгүй байх
 - e. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдөхгүй байх
4. Хуулийн төслийн бүтцийг тодорхойл
 - a. Гарчиг-зүйл-заалт-дэд заалт-хэсэг
 - b. Гарчиг-хэсэг-зүйл- заалт-дэд заалт
 - c. Хэсэг-гарчиг-заалт-дэд заалт-хэсэг
 - d. Гарчиг-зүйл-хэсэг-заалт-дэд заалт
5. Хуулийн төсөлд тавих нэр томъёо, хэл зүйн шаардлага (үл хамаарахыг ол)
 - a. Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх
 - b. Нэр томъёог үндсэн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн утгаар хэрэглэх
 - c. Хүч оруулсан нэр томъёог хэрэглэхгүй байх
 - d. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх
 - e. Үг хэллэгийг хоёрдмол утгагүй, товч тодорхой хэрэглэх
6. Тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбоотойгоор хууль тайлбарлах нь:
 - a. Аутентик тайлбар
 - b. Норматив тайлбар
 - c. Эрх зүйн тайлбар
 - d. Казуаль тайлбар
7. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг судалдаг нь:
 - a. Нормативизм

- b. Эрх зүйн онол
 - c. Эрх зүйн догматик
 - d. Эрх зүйн социологи
8. Эрх зүйн үндсэн зорилго
- a. Хүний эрх чөлөөг хамгаалах
 - b. Төрийн дур зоргыг хязгаарлах
 - c. Шударга ёсыг тогтоох
 - d. А, Б хариулт зав
 - e. А,В хариулт зөв
9. Эрх зүйд тавигдах формаль шаардлага
- a. Энгийн байх
 - b. Тодорхой байх
 - c. Үйлчлэх ирээдүйтэй байх
 - d. А, Б хариулт зав
 - e. А,В хариулт зөв
10. Аль нь агуулгын хувьд хамгийн өргөн хүрээтэй ойлголт вэ?
- a. Эрх зүйн зарчим
 - b. Эрх зүйн хэм хэмжээ
 - c. Эрх зүйн институт
 - d. Эрх зүйн зорилго
11. Эрх зүйн эрх чөлөө нь:
- a. Тодорхой үйлдэл хийх эрх
 - b. Хүссэнээ хийх эрх
 - c. Эрхийн боломж
12. Бодит эрх чөлөө нь:
- a. Эрхийн боломж
 - b. Тодорхой үйлдэл хийх эрх
 - c. Сонгох эрх чөлөө
13. Эрх зүйн либертар концепцийг баримтлагчид эрх зүй, төрийн хамаарлыг хэрхэн үздэг вэ?
- a. Эрх зүй төрийн эсрэг байдаг
 - b. Эрх зүй эрх мэдлийн эсрэг байдаг
 - c. Эрх зүй төрд захирагдмал байдаг
14. Эрх зүйн үнэт зүйл нь:
- a. Эрх зүйн санаа
 - b. Хүний хүсэл зориг
 - c. Хууль тогтоогчийн хүсэл зориг
15. Норматив арга нь:
- a. Эрх зүйн үзэгдлүүдийг харьцуулан судалдаг арга
 - b. Эрх зүйн бясалгал, сэтгэлгээг судалдаг арга
 - c. Эрх зүйг байх ёстой хэм хэмжээтэй жишиж үнэлэлт өгөх арга

16. Эрх зүйн бодит байдлын талаар аналитик арга зүй нь эрх зүйг:
- Төрийн захирамжлах үзэгдэл
 - Нийгмийн харилцааны хэлбэр
 - Эрх зүйн аксеологи ойлголт
17. Эрх зүйн бодит байдлын талаар социологийн арга зүй нь эрх зүйг:
- Төрийн захирамжлах үзэгдэл
 - Нийгмийн харилцааны хэлбэр
 - Эрх зүйн аксеологи ойлголт
18. Эрх зүйн бодит байдлын талаар норматив арга зүй нь эрх зүйг:
- Төрийн захирамжлах үзэгдэл
 - Нийгмийн харилцааны хэлбэр
 - Эрх зүйн аксеологи ойлголт
19. Эрх зүйн хэм хэмжээний үйлчлэх 3 үндсэн орчин
- Хилийн доторх нутаг дэвсгэр
 - Цаг хугацааны орчин
 - Хамааралт этгээдийн орчин
 - Нутаг дэвсгэрийн орчин
20. Эрх зүйн чиг үүргийг нийгмийн амьдралын хүрээ хязгаарт нөлөөлж буй шинж байдлаар нь яаж ангилах вэ?
- Эдийн засгийн хүрээн дэх чиг үүрэг
 - Олон улсын эрх зүйн чиг үүрэг
 - Улс төрийн хүрээн дэх чиг үүрэг
 - Ёс суртахуун оюун санааны хүрээн дэх чиг үүрэг
 - Экологийн хүрээн дэх чиг үүрэг
21. Эрх зүйн эх сурвалжид аль нь хамаарах вэ?
- Эрх зүйн тогтолцоо
 - Эрх зүйн хэм хэмжээний акт
 - Зан заншил
 - Эрх зүйн шинжтэй гэрээ
 - Шүүхийн прецедент
22. Эрх зүйн эх сурвалжийн бүрдлийг ол
- Эрх зүйн сургалт
 - Материаллаг эх сурвалж
 - Түүх, танин мэдэхүйн эх сурвалж
 - Хууль зүйн эх сурвалж
 - Эрх зүйн фетишизм
23. Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах “казуаль” тайлбар
- Албан ёсны
 - Албан ёсны бус
 - Номлолын
 - Аль нь ч биш
24. Ром-Германы эрх зүйн үүсэл хөгжилд шууд нөлөөлсөн эрх зүйн эх сурвалж /үл хамаарахыг ол/

- a. Орон нутгийн заншил
 - b. Худалдааны заншил
 - c. Католик сүм хийдийн эрх зүй
 - d. Жам ёсны эрх зүй
25. Төрийн байгууллагыг байгуулагдах аргаар нь:
- a. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх
 - b. Сонгогдсон, томилогдсон
 - c. Ганцаарчилсан, хамтын
 - d. Төв ба орон нутгийн
26. Иргэний эрх зүйн зохицуулалтын арга нь
- a. Императив
 - b. Диспозитив
 - c. Урамшуулалт
 - d. Зөвлөмжилсэн
27. Эрх зүй ба ёс суртахууны ялгагдах гол шинж нь
- a. Агуулга
 - b. Хэлбэр
 - c. Биелүүлэх арга
 - d. Зорилго
28. Эрх зүйн тогтолцооны анхны бүрдүүлбэр нь
- a. Үндсэн хууль
 - b. Хууль
 - c. Хэм хэмжээ
 - d. Засгийн газрын тогтоол
29. Европын эрх зүй нь:
- a. Германы эрх зүй
 - b. Бүс нутгийн эрх зүй
 - c. Английн эрх зүй
 - d. Францын эрх зүй
30. Социалист эрх зүйн тогтолцооны гол онцлог
- a. Хувийн ба нийтийн эрх зүйн зааг ялгаа байгаагүй
 - b. Субъектүүд эрх тэгш
 - c. Үндэсний эв нэгдлийг хангасан
 - d. Хөдөлмөрийн хүний сайн сайхны төлөө анхаарал тавьсан
31. Эрх зүйг туйлшруулах үзэл нь
- a. Хуульд захирагдахгүй байх
 - b. Хуулийг газар сайгүй мөрдөхгүй байх
 - c. Хуулийг хэтрүүлэн үнэлэх
 - d. Хүний эрх, эрх чөлөөг зөрчих
32. Эрх зүйн харьцуулсан шинжилгээ хийх макро түвшин нь
- a. Эрх зүйн ухагдахуун
 - b. Эрх зүйн институт
 - c. Эрх зүйн хэм хэмжээ

- d. Эрх зүйн бүл
33. Хувийн эрх зүй:
- a. Худалдааны эрх зүй
 - b. Санхүүгийн эрх зүй
 - c. Газрын эрх зүй
 - d. Хот байгуулалтын эрх зүй
34. Хууль, эрх зүйг төсөөтэй хэрэглэж болох хүрээ
- a. Эрүүгийн хариуцлага
 - b. Захиргааны хариуцлага
 - c. Сахилгын хариуцлага
 - d. Иргэний эрх зүйн хариуцлага
35. Мусульманы эрх зүй нь аль ангилалд багтах вэ?
- a. Өрнийн эрх зүйд
 - b. Шашны эрх зүйд
 - c. Азийн эрх зүйд
 - d. Дорно дахины эрх зүйд
 - e. Еврейн эрх зүйд
36. Үндсэн хуулийг онолын хувьд тайлбарлах субъект
- a. Парламент
 - b. Дээд шүүх
 - c. Үндсэн хуулийн шүүх
 - d. Захиргааны шүүх
37. БНХАУ-ын эрх зүйн тогтолцоо нь:
- a. Эх газрын
 - b. Англо-Саксоны
 - c. Социалист
 - d. Мусульманы
38. Civil Law системд заавал биелэгдэх эрх зүйн эх сурвалж
- a. Үндсэн хууль
 - b. Худалдааны заншил
 - c. Шударга ёсны зарчим
 - d. Оюун ухаан
 - e. Каноны эрх зүй
39. Аутентик тайлбар нь
- a. Хууль зүйн хүчин чадлын
 - b. Цар хүрээний
 - c. Аргачлалын
 - d. Номлолын
40. Эрүүгийн хууль тогтоомжийг буцаан хэрэглэхийг хориглох нь:
- a. Nullam crimen sine lege
 - b. Nulla poena sine lege
 - c. Презумци

- d. Зөв хариулт алга байна.
41. Эрх зүйн аль тогтолцоонд шүүгч мөрдөн шүүх үүрэг гүйцэтгэдэг вэ?
- a. Англо-америкийн
 - b. Эх газрын
 - c. Мусульманы
 - d. Зөв хариулт алга байна
42. Орчин үеийн төр судлал дахь хандлага
- a. Төрийн оролцоог багасгах
 - b. Төрийг бэхжүүлэх
 - c. Төр ёсны уламжлалыг хадгалах
43. “Common Law” тогтолцооны “Civil Law” тогтолцооноос ялгарах гол ялгаа
- a. Эрх зүйн заншил
 - b. Шүүхийн жишиг
 - c. Хууль тогтоогчдын тогтоосон хууль давуу
 - d. Нийтлэг эрх зүйг хүлээн зөвшөөрөх
44. Rule of law бол
- a. Төрд хамаатай зарчим
 - b. Иргэнд хамаатай ойлголт
 - c. Шүүхэд хамаатай
 - d. Зөв хариулт алга байна.
45. “Төр, эрх зүйн онол” гэсэн судлагдахуун үүсэх болсон үндэслэл
- a. “Эрх зүй”, “Эрх зүйн хэм хэмжээ” гэсэн ойлголтууд адилхан
 - b. Эрх зүй-төрийн бүтээгдэхүүн
 - c. Жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрөх
 - d. Эрх зүйн уг чанарыг судлах
46. Эрх зүйн шинжлэх ухаанд төрийн онолын гол үүрэг
- a. Арга зүйн
 - b. Хэм хэмжээний
 - c. Эрх зүйн хэм хэмжээний шинж чанарыг таних
 - d. Харьцуулалтын
47. Хууль зүйн техник нь:
- a. Эрх зүйн агуулгын тал
 - b. Хэлбэрийн тал
 - c. Эдгээрийн нэгдэл
 - d. Аль нь ч биш
48. Дараах бодомжоос аль нь зөв бэ?
- a. Эрх зүй нь төрөөс өмнө байдаг.
 - b. Эрх зүй нь гагцхүү төртэй холбоотой үүсдэг
 - c. Төр нь эрх зүйг үүсгэдэг
 - d. Төр, эрх зүй хоёр зэрэг үүссэн

49. Эрх чөлөөг эрх зүйн тухай ойлголтын цөмд тавьдаг онол
- a. Социологи онол
 - b. Жам ёсны эрхийн онол
 - c. Ёс зүйн онол
 - d. Позитив онол
 - e. Либертари онол
50. Эрх зүйн либертари онолын үүднээс Үндсэн хуульд хүний үндсэн эрхийг тоочиж байгаа нь:
- a. Зөвшөөрч байгаа хэрэг
 - b. Баталгаажуулж байгаа хэрэг
 - c. Эрхийг нь тогтоож өгч байгаа хэрэг
 - d. Хамгаалж байгаа хэрэг